# 2024 оны Шинэ Millionaire Team-ийн Лидерүүдийн арга хэмжээ

## Арга хэмжээний дүрэм болон нөхцөлүүд – Асуулт ба хариулт

- Арга хэмжээ: 2024 оны Шинэ Millionaire Team-ийн Лидерүүдийн арга хэмжээ
- Болох өдөр: нэмэлтээр мэдэгдэх болно
- Болох газар: нэмэлтээр мэдэгдэх болно

## Арга хэмжээний болзлууд

- Болзол: 2023 оны 4-р сарын 1-ээс 2024 оны 3-р сарын 1-ний хооронд Шинээр Millionaire Team* статуст хүрсэн гишүүд, статуст хүрснээс хойших дараалсан 6 сарын хугацаанд дурын нэг сард 4%-ийн Борлуулалтын Урамшууллыг авсан байх.

*Болзлын жишээ:*
*2023 оны 5-р сарын 1-нд Шинэ Millionaire Team статуст хүрсэн тохиолдолд:*

<table>
<tr><th>5-р сар</th><th>6-р сар</th><th>7-р сар</th><th>8-р сар</th><th>9-р сар</th><th>10-р сар</th><th>Болзол хангасан уу?</th></tr>
<tr><td>Millionaire Team-статуст хүрсэн</td><td></td><td></td><td>4%-ийн Борлуулалтын Урамшуулал авсан</td><td></td><td></td><td rowspan="2">Тийм, 2024 оны Шинэ Millionaire Team-ийн Лидерүүдийн арга хэмжээний болзлыг хангасан байна.</td></tr>
<tr><td>Хүлээлгийн хугацаа – 2 сар. Millionaire Team статуст хүрснээс хойш 4%-ийн Борлуулалтын Урамшууллыг авч эхлэх хүртэл 2 сарын хугацаанд хүлээнэ.</td><td colspan="5">Статуст хүрснээс хойших дараалсан 6 сарын хугацаанд дурын нэг сард 4%-ийн Борлуулалтын Урамшууллыг авсан байх шаардлагатай. (2023 оны 7-р сараас эхлэн 10-р сарын хооронд)</td></tr>
</table>

*Millionaire Team гишүүд 4%-ийн Борлуулалтын Урамшууллыг авахын тулд сар тус бүр 4000 Роялти Оноо болон 3000 Нийт Оноо цуглуулснаар авах боломжтой.

## Арга хэмжээний бэлэг

- Тансаг зэрэглэлийн зочид буудалд байрлах
- Онцгой бэлгийн багц
- Нислэгийн тийз болон онгоцны буудлаас тосох үйлчилгээ
- Топ Лидерүүдээс авах сургалтууд
- Лидерүүдтэй биечлэх уулзах боломж
- Тусгай хүлээн авалт/оройн зоог

© Herbalife Europe Limited. All Rights Reserved. Q&A – VERSION 2, EMEA Member Communication, May-2023

## Арга хэмжээний дүрэм болон нөхцөлүүд

- **Манлайллын арга хэмжээ нь бүс нутгийн дараах улс орнуудад нээлттэй:** Австри, Бельги, Босни ба Херцеговин, Ботсвана, Хорват, Кипр, Чех, Дани, Финлянд, Франц, Герман, Гана, Грек, Унгар, Исланд, Израил, Ирланд, Итали, Ливан, Косово, Ливан, Лесото, Хойд Македон, Мальта, Мальдив, Монтенегро, Намиби, Голланд, Норвеги, Польш, Португал, Румын, Серби, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Орос, Эсватини, Швед, Швейцар, Турк, Их Британи, Замби, Армени, Беларусь, Азербайжан, Эстони, Гүрж, Казахстан, Киргиз, Латви, Литва, Монгол, Узбекистан, Украин.
- Бие Даасан Гишүүд ёс зүйн зөрчилгүй байх шаардлагатай.
- Арга хэмжээнд Бие Даасан Гишүүдийг урих/оролцуулах нь Herbalife-ийн шийдвэр юм.
- Хэрвээ арга хэмжээний болзлын оноо бүтээгдэхүүний буцаалттай холбоотойгоор оноо дахин тооцоологдсон тохиолдолд энэхүү арга хэмжээний урилгыг хүчингүй болгох эрсдэлтэйг анхаарна уу.
- Компанийн зүгээс Бие Даасан Гишүүд арга хэмжээнд оролцоход гадаад паспорт, виз болон бусад шаардлагатай бичиг баримтыг компаниас хариуцахгүй болно.
- Визний захидлыг хүсэлтийн дагуу авах боломжтой ба харин визний хураамжийг Бие Даасан Гишүүн өөрсдөө хариуцна.
- Бие Даасан Гишүүн хүндэтгэх шалтгаанаар (виз олгохоос татгалзсан, эрүүл мэндийн шалтгаан зэрэг асуудлаас) арга хэмжээнд оролцох боломжгүй тохиолдолд дараагийн арга хэмжээнд урих зэргээр харгалзан үзэх боломжтой, гэвч боломжит байдлаас шалтгаалан нөхцөл байдал өөрчлөгдөх боломжтой.
- Herbalife компаниас Бие Даасан Гишүүдийн даатгалын зардлыг хариуцахгүй болно.
- Бие Даасан Гишүүд аливаа татварыг өөрөө төлөх үүрэгтэй.
- Хамгийн ихдээ 2 хүний урилга авах боломжтой. Анхаарах: Бие Даасан Гишүүний гэрээнд бүртгэлтэй эхнэр/нөхөр, хамтран амьдрагч нь арга хэмжээнд оролцох боломжтой, харин эхнэр/нөхөр, хамтран амьдрагч нь арга хэмжээний болзлыг хангаагүй тохиолдолд зөвхөн хүлээн авалт, үдэшлэг, аялал зэрэг хөтөлбөрт оролцох боломжтой бөгөөд сургалт болон бизнес уулзалтуудад оролцох боломжгүй. Мөн Бие Даасан Гишүүн гэр бүлээс гадна найз нөхдөө энэ арга хэмжээнд авчрахыг хориглоно.
- Уг арга хэмжээнд хүүхдүүд оролцохыг хориглоно. Хүүхэдтэй хөхүүл эхчүүдийг харгалзан үзнэ.
- Herbalife компани нь арга хэмжээний гэрэл зураг, видео бичлэг хийх бүрэн эрхтэй бөгөөд нэмэлт төлбөргүй ашиглах үүрэгтэй.

Хэрэв энэ баримт бичигт тусгагдаагүй нэмэлт асуулт байвал бүс нутгийн ажилтантай холбогдоно уу.

© Herbalife Europe Limited. All Rights Reserved. Q&A – VERSION 2, EMEA Member Communication, May-2023